

ХАМТЫН АЖИЛЛАГАА

Геологийн мэдээллийн “Монгоеокат” систем нэвтрүүлэв

О.БАТЖАРГАЛ

Ашигт малтмал, газрын тосны газар (АМГТГ) болон Австралии улс хамтран “Монгоеокат” систем нэвтрүүлснээ өнгөрсөн баасан гаригт мэдээлэв. Геологийн мэдээ, мэдээллийг олон улсын жишигт нийцүүлэх, хэрэглэгчдэд түргэн шуурхай, бодитоор хүргэх чиглэлээр Монгол Улсын геологийн мэдээллийн каталог (Монгоеокат) системийг тус улстай хамтран нэвтрүүлсэн нь энэ аж. “Монгоеокат” нь геологийн мэдээллийн хураангуйг хэрэглэгчдэд хүргэх зорилготой хоёр бүрэлдэхүүн хэсэгтэй нэгдсэн систем юм. Хэрэглэгч энэ системээс веб газар зүйн мэдээллийн орчинд орон зайн хайлт хийж, төрөл бүрийн суурь зураг, жижиг, дунд масштабтай геологи, сансрын зургууд, ашигт малтмалын ордуудын байршил зэргийг хайх боломжтой болжээ.

АМГТГ-ын дарга Б.Баатарцогт “Монгоеокат систем нь Австралии улсаас манайц суугаа Элчин сайд Жон Лантригийн хэрэгжүүлсэн томоохон ажил. Энэ цахим үйлчилгээг орчин үеийн технологид сууринтуулан байгуулах ажилд гүн туслалцаа үзүүлсэн тус улсын Засгийн газар, хамтарч ажилласан хүмүүст талархал илэрхийлье” гэв.